



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 20

Баруун-Урт

Усны аюулгүй байдлын төлөвлөгөө
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, "Усны тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилго бүхий 2018-2020 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамруулан санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбаатар/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга /А.Чулуунбат/-д үүрэг болгосугай.

Хавсралт 5 хуудас.

ДАРГА

Б.МӨНХБАТ

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2018

оны 05 сарын 21 ны өдрийн

20 дугаар тогтоолын хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ СУМЫН ХҮН АМЫН УНДНЫ УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД 2018-2020 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үүсч болох эрсдлүүд	Сайжруулах арга замууд	Хэрэгжүүлэх ажил	Шаардагдах хөрөнгө /сая төгрөг/	Хөрөнгийн эх үүсвэр	Хугацаа			Хариуцан гүйцэтгэх эзэн	Тайлбар
						2018	2019	2020		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Ундны усны эх үүсвэрийн тэжээгдлын муж тогтоогоогүй	Тэжээгдлийн муж, усны нөөцийг тогтоох, хамгаалалтанд авах	Төрийн захиргааны болон байгаль орчин хууль хяналтын мэргэжлийн байгуулагаар тогтоолгох	50 сая	АЗДТГазар	+			БОАЖГазар Дөрвөлж ОНӨҮГ	
2	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн энгийн хамгаалалтын бүсийн дэглэм мөрдөж ажиллаагүй	БОНХАЖС, БХБСайдын 2015 оны А-230/127 тоот хамтарсан тушаалын дагуу хийж байршуулах	Эх үүсвэрийн энгийн хамгаалалтын бүсийн дэглэм тогтоож, тэмдэг тэмдэгжүүлэлт файз хийх ,эх үүсвэрийг хамгаалж хашаажуулах зориулалтын дагуу хийж байршуулах	30 сая	"Дөрвөлж" компани	+			АЗДТГазар, БУСЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, МХГазар, ГХБХБГазар БОАЖГазар	
3	Ундны усны эх үүсвэрт хортон ,мэрэгчтэй байна	Хортон мэрэгчийг устгах арга хэмжээ авах, хяналт тавих	Механик аргаар хортон мэрэгч устгах, дахин үржихээс сэргийлэх арга хэмжээ авч мэргэжлийн байгууллагаар устгуулах	5 сая	"Дөрвөлж" компани	+			АЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, МХГазар ЭМГазар БОАЖГазар	

4	Аваарын үед эрчим хүчний нөөц эх үүсвэр байхгүй	Аворын үед ашиглах нөөц дизелтэй болох.	Эрчим хүчний нөөц, эх үүсвэр болох 380-ын мотор, цахилгаан эх үүсвэрийг хангах	15x7=105сая	АЗДТГазар		+		АЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, ОБГазар
5	Ундны усны эх үүсвэрт нөөц эх үүсвэргүй	Усны эх үүсвэрт нөөц шинэ усны эх үүсвэртэй болох	Нөөц цооног ухах, худаг барьж холболтыг хийх	70 сая	"Дөрвөлж" компани	+	+	+	АЗДТГазар, БУСЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, МХГазар,
6	Усны эх үүсвэрт хими ,хүнд металлын дэлгэрэнгүй шинжилгээ хийлгэх	Жилд нэг удаа хими хүнд металлын дэлгэрэнгүй шинжилгээг хийлгэж хэвших	Хүнд металлын шинжилгээг мэргэжлийн байгууллага болох нийгэмийн эрүүл мэндийн хүрээлэнд дээж өгч шинжилгээ хийлгүүлж байх, Шаардлагатай үед хүнд металл тоорхойлох багаж тоног төхөөрөмжийг нийлүүлэх	2 сая	"Дөрвөлж" компани	+	+	+	Дөрвөлж ОНӨҮГ, ЭМГазар, МХГазар
7	Гүний худаг, өргөлтийн насос станцыг автомат горимд шилжүүлэх	Насосны хүчин чадалыг өргөтгөх	Холболтын ажлыг хийх, бүрэн автомат системд оруулах	130 сая	АЗДТГазар "Дөрвөлж" компани		+		АЗДТГазар, БУСЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, МХГазар, ГХБХБГазар БОАЖГазар
8	Төвлөрсөн шугамын ус түгээх цэгүүдийг ухаалаг системд шилжүүлэх	Үе шаттайгаар жилдээ 3-4 ус түгээх цэгийг холбох	Холболтын ажлыг хийх, бүрэн автомат системд оруулах	11x8.5=93.5 сая	БУСЗДТГазар "Дөрвөлж" компани				АЗДТГазар, БУСЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ
9	Усны эх үүсвэрт ус зайлуулах суваг байхгүй	Гүний худгийн хориглолтын бүсэд ус зайлуулах суваг хийх	3-н гүний худагт ус зайлуулах сувгийг хийх	2x3=6 сая	"Дөрвөлж" компани	+	+	+	АЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, МХГазар БОАЖГазар
10	Ус түгээх байрууд хамгаалалтын бүс байхгүй	4 талт 5м-ын зайд хайс хашаа татах ,хамгаалалтын бүстэй болгох	Хашаа хайс хэмжээг гаргах шаардлага хангасан материалыг худалдан авч хамгаалалтын бүс хийх	35 сая	"Дөрвөлж" компани	+	+	+	АЗДТГазар БУСЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, МХГазар, ГХБХБГазар

11	Иргэдэд түгээж буй ундны усанд байнгын хяналт шинжилгээ хийгддэггүй	Усан хангамжийн байгууллагат дотоод хяналтын тогтмол үйл ажиллагаатай лаборатори байгуулах	Дотоод хяналтын лаборатори байгуулж шаардагдах тоног төхөөрөмж, шил сав, бодисоор хангах үйл ажиллагааг тогтмолжуулах	60 сая	"Дөрвөлж" компани	+			АЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, МХГазар
12	Эх үүсвэрийн усны чанарын хяналтгүй	Усны чанарыг тодорхойлох арга хэмжээ авах	Эх үүсвэрийн гүний худаг дээр усны чанарыг тодорхойлдог мониторингийн цооног байгуулах	30 сая	Улсын төсөв "Дөрвөлж" компани	+	+	+	АЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, МХГазар
13	Аваарын үед ус түгээх усны нөөц машин байхгүй	Шинэ нөөц усны машинаар хангаж иргэдийн ус авахад хүлээлт үүсгэхгүй байлгах	Парк шинэчлэл хийх, Усны машины нөөцтэй байх	150 сая	АЗДТГазар "Дөрвөлж" компани		+		АЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, ОБГазар
14	Ард иргэд, сургууль цэцэрлэг ундны усыг хайрлан хамгаалах, гамнах усыг зүй зохистой ашиглах талаарх ойлголт дутмаг байна.	Ундны усыг хайрлан гамнах, эрүүл аюулгүй ус хэрэглэх, гэрийн нөхцөлд усыг зөв хадгалж хэвших зэрэг ойлголтыг өгөх	Багийн гишүүдээс Сургагч багш бэлтгэх, шат дараалласан сургалт семинарын ажлыг зохион байгуулах /усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх/	12 сая	"Дөрвөлж" компани	+	+	+	АЗДТГазар, БУСЗДТГазар, Дөрвөлж ОНӨҮГ, МХГазар, ЭМГазар, БОАЖГазар, ОБГазар, УЦУОШАлба, Мэнэнгийн тал сав газар,
15	Ус хангамжийн эх үүсвэр, усан сангийн харуул хамгаалалт	Гэрээ байгуулан ажиллах	Дотоодын цэрэг эсвэл цагдаагын байгууллагаар хамгаалалт хийлгэх		АЗДТГазар	+	+	+	АЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, ОБГазар
16	Цэвэр усны түгээлтийн шугам сүлжээг сохих, шинэчилэх	Судалгааг гаргаж зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж улсын төсөвт суулгах	Нийт 5.5 км 30-40 жил болсон шугам сүлжээг сохих	1.4 тэр бум	Улсын төсөв		+	+	АЗДТГазар Дөрвөлж ОНӨҮГ, ГХБХБГазар
17	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна болон дотор цэвэр	Шугам сүлжээг шинэчилэх	Аймаг орон нутагт санал дэвшүүлж тухайн байрнуудын шугам сүлжээг хэсэгчилэн болон	750 сая	АЗДТГазар	+	+	+	АЗДТГазар, БУСЗДТГазар, Дөрвөлж ОНӨҮГ,

	усны шугам сүлжээний насжилт хугацаа дууссан элэгдэлд орсон		бүрэн шинэчилж солих						ГХБХБГазар	
18	Цэвэр усны насос станц №5 дээр хоолны давснаас хлор гаргаж авах төхөөрөмж суурилуулах	Хүчин чадалд тохирсон тоног төхөөрөмжийн сонголтыг хийх	Тоног төхөөрөмжийг суурилуулах байнгын ашиглалтанд оруулах	75 сая	АЗДТГазар "Дөрвөлж" компани	+	+		АЗДТГазар, БУСЗДТГазар, Дөрвөлж ОНӨҮГ	
19	Ус нөөцлүүрийн өргөтгөл шинэчилэлтийн ажил	Батлагдсан зураг төсөв хийлгэх бэлтгэл ажлыг хангах	5000-6000м3 эзэлхүүнтэй ус нөөцлүүр санг барьж байгуулах	1.5 тэр бум	Улсын төсөв	+	+	+	АЗДТГазар, БУСЗДТГазар, Дөрвөлж ОНӨҮГ, ГХБХБГазар	
20	Гүний худаг өргөлтийн насос станцуудын усны тоолуурыг солих	Электрон усны тоолуурын сонголтыг хийх	Электрон усны тоолуур суурилуулах-11ш	33 сая	"Дөрвөлж" компани	+	+		АЗДТГазар, БУСЗДТГазар, Дөрвөлж ОНӨҮГ	
21	Иргэдийн хэрэглэж буй хүнсний нөөцийн сав зориулалтын бус	Хүнсний зориулалтын нөөцийн савтай болгох	Иргэдэд сургалт сурталчилгаа хийх, хүнсний зориулалтын саваар хангах	60 сая	БУСЗДТГазар "Дөрвөлж" компани	+	+		АЗДТГазар, БУСЗДТГазар, Дөрвөлж ОНӨҮГ	

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

Ажлын хэсгийн ахлагч: Сүхбаатар аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: “Дөрвөлж” ОНӨҮГазрын Захирал

Гишүүд:

“Дөрвөлж” ОНӨҮГазрын Ерөнхий инженер

“Дөрвөлж” ОНӨҮГазрын УСАЗ-ын инженер

“Дөрвөлж” ОНӨҮГазрын Усны чанарын инженер

“Дөрвөлж” ОНӨҮГазрын Усны Техникч

ТЕГазар Сүхбаатар аймаг дахь хэлтэс

АЗДТГазрын БОАЖ хариуцсан мэргэжилтэн

АЗДТГазрын эрүүл мэндийн бодлогын мэргэжилтэн

БОАЖГазар усны асуудал хариуцсан мэргэжилтэн

МХГ-ын ЭАХХ хяналтын улсын байцаагч

ЭМГ-ын мэргэжилтэн

БУЗДТГазрын байгаль орчны байцаагч

Буйр нуур- Мэнэнгийн талын сав газрын захиргааны мэргэжилтэн

ОБГазрын дарга

УЦУОШГазар Лабораторын эрхлэгч

Хэрэглэгчийн төлөөлөл

Т.Амарбаатар 99086901

О.Дүүрэнбилэг 99055631

Ч.Алдарбат 99512345

Б.Буджав 89770255

Э.Учрал 99515831

Э.Бат-Отгон 94000813

З.Золжаргал 88089114

Д.Отгонзул 99442122

М.Дэлхийцэцэг 99519082

Н.Мөнхбаатар 99519493

Э.Сансартайван 99107506

Э.Анхбаяр 95215252

Н.Гантөмөр 99036787

Э.Болорчимэг 99123929

Х.Жамъянсүрэн 88711932

Н.Мөнхбаяр 99719765

Г.Баянжаргал 89770279